

**ЖИМС ЖИМСГЭНИЙН ТАРИАЛСАН ТАЛБАЙ, УРГАЦ ХУРААЛТЫН 20.. ОНЫ МЭДЭЭ
(А-ХАА-5)-НИЙ МАЯГТ НӨХӨХ ЗААВАР**

Энэхүү маягтыг тухайн нутаг дэвсгэртээ жимс, жимсгэнийн бут тарьж ургуулан, түүнээс үр жимс, ургац авсан өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, өрхөөс нөхөж авна.

Тариалсан талбайн хэмжээг "га"-аар, хураасан ургацын хэмжээг "кг"-аар, бут модны тоог "ширхэг"-ээр хэмжиж, бүртгэнэ.

I.ХАЯГИЙН ХЭСЭГ

1.Байршил: Аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн харьяалагдах аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэр, кодыг маягтын зааварт тусгасан засаг захиргааны нэгжийн кодоос харж нөхнө.

2.Аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл: УБЕГ-аас олгосон регистрийн дугаар, байгууллагын нэр, холбоо барих утасны дугаарыг бичнэ.

3.Өрхийн мэдээлэл: Тухайн өрхөд харьяалах баг, хорооноос олгосон 13 оронтой "Өрхийн бүртгэлийн дэвтрийн дугаар"-ыг бичнэ. Тухайн өрхийн тэргүүлэгчийн овог, нэр, холбоо барих утасны дугаарыг бичнэ.

*БҮНА-2.1 код- Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангилал-2.1 код.

II. ТАРИАЛСАН ТАЛБАЙ, УРГАЦ ХУРААЛТ

1 дүгээр баганад жимс, жимсгэнийн бут, модны тариалсан талбай, жимс, жимсгэнийн ургац болон хэрэглээний нийт хэмжээг асууж нөхнө.

2-10 дугаар баганад жимс, жимсгэнийн тариалсан талбай, хураасан ургац, хэрэглээг жимсний төрлөөр ангилан нөхнө. Хураасан алимын ургацад том алим, бэсрэг алим, давжаа алимыг оруулна.

1 дүгээр мөрөнд жимс, жимсгэнийн бут, модны тариалсан талбайн хэмжээг нөхнө. Тариалсан талбайг маягтад тусгагдсан жимс, жимсгэнийн төрлөөр ангилан нөхнө.

2 дугаар мөрөнд хүлэмжид тарьсан жимс жимсгэнийн бут, модны тариалсан талбайн хэмжээг нийт тариалсан талбайгаас сугалж нөхнө. **(Мөр1≥мөр2)**

3 дугаар мөрөнд нийт суулгасан мод, бутны тоог жимс, жимсгэнийн төрлөөр ангилан нөхнө.

4 дүгээр мөрөнд тухайн жилд үр жимсээ өгөх мод, бутны тоог жимс, жимсгэнийн төрлөөр ангилан нөхнө. **(Мөр3≥мөр4)**

5 дугаар мөрөнд ургац хураалтын өмнөх хорогдлын дүнг нөхнө. Ургац хураалтын өмнөх хорогдол гэж ургац хураалт эхлэхээс өмнө тохиолдох бөгөөд шавж, хачиг, мэрэгч амьтан, шувуу зэргээр сүйтгэгдэх болон ургацад гэмтэл учруулж, өвчлүүлэх хогийн ургамал, ургамлын өвчин зэргээс бий болсон хорогдлыг хамруулна.

6 дугаар мөрөнд хураасан ургацын хэмжээг асууж нөхнө. Хураасан ургацад тухайн жилд хураан авсан жимс, жимсгэнийн ургацын хэмжээг оруулна. **(Мөр6=мөр(8:10))**

7 дугаар мөрөнд хүлэмжээс хураасан ургацын дүнг нийт хураасан ургацын дүнгээс сугалж нөхнө. **(Мөр6≥мөр7)**

8 дугаар мөрөнд ургац хураалтын хорогдлын дүнг нөхнө. Ургац хураалтын явцад тохиолдох ба хураасан ургацыг үтрэмд цэвэрлэсний дараа стандартын шаардлага хангахгүй, цаашид ашиглалтад нийцэхгүй болсон хорогдлыг хамруулна. **(Мөр6≥мөр8)**

9 дүгээр мөрөнд ургац хураалтын дараах хорогдлын дүнг нөхнө. Ургац хураасны дараа боловсруулалтын шат хүртэлх гарсан аливаа хорогдлыг хамруулна. Үүнд:тэвэрлэлтээс, хадгалалтаас, савлалтаас бий болсон хорогдлыг хамруулна. **(Мөр6≥мөр9)**

10-16 дугаар мөрөнд хураасан ургацын цэвэр жинг нийт хураасан ургацаас хорогдлыг хасаж тодорхойлж, зах зээлд борлуулсан, үйлдвэрийн газар борлуулсан, өрхийн хэрэглээнд зарцуулсан, нөөцөлсөн, ажилчдад цалин хөлс хэлбэрээр олгосон, бусад гэсэн ангиллаар хэрэглэсэн жимс жимсгэнийн хэмжээг нөхнө. **(Мөр10=мөр(11:16)), (Мөр10=мөр(6-8-9))**

11 дүгээр мөрөнд зах зээлд борлуулсан жимс, жимсгэнийн ургацын хэмжээг нөхнө. **(Мөр10≥мөр11)**

12 дугаар мөрөнд үйлдвэрийн газарт борлуулсан жимс, жимсгэнийн ургацын хэмжээг нөхнө. **(Мөр10≥мөр12)**

13 дугаар мөрөнд өөрийн хэрэглээнд зарцуулсан жимс, жимсгэнийн ургацын хэмжээг асууж нөхнө. Өөрийн хэрэглээнд зарцуулсан ургацад хүнсэнд болон үйлдвэрийн бүтээгдэхүүн хийхэд түүхий эд материал болгон ашигласан ургацыг хамруулна. **(Мөр10≥мөр13)**

14 дүгээр мөрөнд үйлдвэрлэлд ашиглах зорилгоор нөөцөлсөн болон зах зээлд борлогдоогүй үлдсэн жимс, жимсгэнийн ургацын хэмжээг нөхнө. **(Мөр10≥мөр14)**

15 дугаар мөрөнд ажиллагчдадаа цалин хөлсний оронд олгосон жимс, жимсгэнийн ургацын хэмжээг нөхнө. **(Мөр10≥мөр15)**

16 дугаар мөрөнд дээр дурдагдаагүй бусад зориулалтаар хэрэглэсэн жимс, жимсгэнийн ургацын хэмжээг нөхнө. **(Мөр10≥мөр16)**

Хураасан ургацын хэмжээг кг-аар, тариалсан талбайн хэмжээг га-гаар илэрхийлэх бөгөөд өөрөөр илэрхийлсэн тохиолдолд доор өгөгдсөн итгэлцүүрийг ашиглан кг, га-д шилжүүлнэ.

Шилжүүлэх итгэлцүүр:

1 га = 10000м² = 100м*100м, 1 сот = 100м² = 10м*10м, 100 сот = 10000м² = 1 га, 1 тонн = 1000 кг, 1000 гр= 1 кг

**Үндэсний статистикийн хороо
Эдийн засгийн статистикийн газар
Холбоо барих утас: 51-261565**

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны 12-р сарын 25-ны өдрийн А/190 дугаар тушаалын IV хавсралтаар батлав.

Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн 22 дугаар зүйлийн 3 дугаар заалтыг үндэслэн мэдээллийн нууцыг хадгална.

А-ХАА-5

**ЖИМС, ЖИМСГЭНИЙН ТАРИАЛСАН ТАЛБАЙ
УРГАЦ ХУРААЛТЫН 20.. ОНЫ МЭДЭЭ**

I. ХАЯГИЙН ХЭСЭГ

1.Байршил	Нэр		Код
Аймаг, нийслэл			
Сум, дүүрэг			
Баг, хороо			
2.Аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл			
Аж ахуйн нэгж, байгууллагын нэр			
Регистрийн дугаар			
Утасны дугаар			
3.Өрхийн мэдээлэл			
Өрхийн тэргүүлэгчийн овог, нэр			
Өрхийн бүртгэлийн дэвтрийн дугаар			
Утасны дугаар			

1. Баг/хорооны засаг дарга аж ахуйн нэгж, байгууллага, өрхөөс мэдээг авч нэгтгэн сум, дүүрэгт 1 дүгээр сарын 10-ны дотор маягтаар ирүүлнэ.
2. Сумын статистикийн асуудал хариуцсан ажилтан, дүүргийн статистикийн хэлтэс 1 дүгээр сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтэст цахим хэлбэрээр дамжуулна.
3. Аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтэс мөн сарын 21-нд Үндэсний статистикийн хороонд цахим хэлбэрээр дамжуулна.

II. ТАРИАЛСАН ТАЛБАЙ, ХУРААСАН УРГАЦ

Код	Үзүүлэлт		МД		Бүгд	Чацаргана	Үхрийн нүд	Алим	Ранетка	Бөөрөлзгөнө	Гүзээлзгэнэ	Ингоор	Чавга	Бусад	
	Хэмжих нэгж	х	в	ш											х
	га	1				0134910	0135100	0134100	0134101	0135300	0135400	0134400	0134600	0135900	
Нийт тариалсан талбай	га	1													
Хүлэмжийн тариалалт	га	2													
Нийт бут, модны тоо	ш	3													
Үр жимсээ өгөх бут, мод	ш	4													
Ургац хураалтын өмнөх хорогдол	кг	5													
Ургац хураалт - бүгд	кг	6													
Хүлэмжийн ургац хураалт	кг	7													
Ургац хураалтын үеийн хорогдол	кг	8													
Ургац хураалтын дараах хорогдол	кг	9													
Хураасан ургац, цэвэр жингээр	кг	10													
мөр10=мөр(11:16)	кг	11													
Зах зээлд борлуулсан	кг	12													
Үйлдвэрт	кг	13													
Өөрийн хэрэглээнд	кг	14													
Нөөцөлсөн	кг	15													
Ажиллагчдад цалин хөлс хэлбэрээр олгосон	кг	16													
Бусад	кг														

ТAMГA
Нягтлан бодогч / эдийн засагч /
Өрхийн тэргүүлэгч
Баг/хорооны засаг дарга

20... оны ...-р сарын ...-ны өдөр